

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан нийт 13.4 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 8 тэргүүлэх чиглэл, 184 төсөл, арга хэмжээг тусгаж, үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 2.3 их наяд төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 0.2 их наяд төгрөг, гадаадын зээлээр 1.3 их наяд төгрөг, гадаадын тусламжаар 0.5 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.5 их наяд төгрөг, хувийн хөрөнгө оруулалтаар 3.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээс 1.6 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Тогтоолын төслийг [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг төлөвлөгөөний төсөлд экспорт болон өрхийн орлогыг нэмэгдүүлэх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийн талаар, Оюутолгойн гүний уурхай ашиглалтад орсноор эдийн засагт үзүүлэх үр дүн, өгөөжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хил холболт хийгдээгүй төмөр замыг холбох төслүүдийн талаар болон нүүрс угааж, баяжуулан нэмүү өртөг шингээх талаар, Дарханы арьс ширний үйлдвэрийн цогцолбор, үйлдвэрлэл, төхнологийн паркуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, хушны самарны экспортын асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр төлөвлөгөөний төсөлд төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлыг хэрхэн шийдвэрлэх, Газрын багц хуулийг хэзээ өргөн мэдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг дотоодын эрчим хүчний хэрэгцээг хангах, эрчим хүч экспортлох төслүүд хэрэгжих боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл төсөлд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэдэн хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийхээр төлөвлөсөн болон төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин боомтын суурьшил, боомт доторх авто зам, эрчим хүчний асуудлыг хэн хариуцах талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд гадаадын хөрөнгө оруулалт татах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх, зарцуулах хүрээнд хийхээр төлөвлөж байгаа арга хэмжээний талаар, нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн тэтгэвэр тэтгэмж, цалин хөлс нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Алтанбулаг чөлөөт бүсийг хэрхэн хөгжүүлэх, Дарханы арьс ширний үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалт, ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн

байгууламжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, боловсруулалтын түвшинг ахиулах, эрчим хүчний эх үүсвэрийн чадлын дутагдлаас гарах, чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих, боомтын дэд бүтцийн асуудлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг хөгжлийн төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хоорондын уялдаа холбоог хангах, хөгжлийн бодлогыг бодитой төлөвлөх, үр дүн хэмжигдэхүйц тодорхой байх, хүрэх үр дүнд суурилж төлөвлөх, төсөвлөх гэсэн саналуудыг хэлсэн болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ц.ЦЭРЭНПУНЦАГ**